



ГОЛОМТ БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 00/04

Улаанбаатар хот

Холбогдох этгээдтэй хэлцэл байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, Банкны тухай хуулийн 17-р зүйлийн 17.9 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Голомт банкны дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.13 дахь заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 сарын 13-ны өдрийн ээлжит хурлыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Банкны холбогдох этгээдтэй байгуулах хэлцлүүдийг энэхүү Тогтоолын Хавсралт №1-т заасан нөхцөлөөр батлахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолоор батлагдах холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүд нь хууль журмын шаардлагыг бүрэн хангасан ба банкны өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд харилцагчдад санал болгож буй ердийн нөхцөлөөс тусгайлан давуу тал олгоогүй болохыг баталгаажуулсугай.
3. Голомт банк ХК-ийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /А.Одонбаатар/-д олгосугай.
4. Энэхүү шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Жэймс Б.Дваер/-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч. МӨНХЦЭЦЭГ